



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

“Ард даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам, заавар”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигч “Бльюпланет” ХХК-ийн эзэмшлийн 16,72 хувь буюу 249,490 ширхэг, хувьцаа эзэмшигч Д.Чулуунцэцэгийн эзэмшлийн 11 хувь буюу 164,200 ширхэг хувьцааг “Ард санхүүгийн нэгдэл” ХК-д худалдахыг зөвшөөрч, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийг энэхүү тогтоолын хавсралтад дурдсанаар өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Ард даатгал” ХХК /Б.Батболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.


ДАРГА



С.ДАВААСҮРЭН

001310

Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
27 дугаар тогтоолын хавсралт



“Ард даатгал” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнээр 2,345.0005/	Дүрмийн санд эзлэх хувь	Хорогдсон	Нэмэгдсэн	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнээр 2,345.0005/	Дүрмийн санд эзлэх хувь
1	“Ард санхүүгийн” нэгдэл ХХК /5042145/	825,537	1,935,884,677.76	55.31%	-	970,103,256.85	1,239,227	2,905,987,934.61	83.03%
2	“Блюпланет” ХХК/5794358/	402,800	944,566,201.40	26.99%	(585,054,174.75)	-	153,310	359,512,026.65	10,27%
3	Д.Чулуунцэцэг	164,200	385,049,082.10	11.00%	(385,049,082.10)	-	-	-	-
4	“Энержиинтернэшнл” ХХК /5790263/	70,000	164,150,035.00	4.69%	-	-	70,000	164,150,035.00	4,69%
5	“Хөрөнгө оруулагч үндэстэн” ХХК /9042104/	30,000	70,350,015.00	2,01%	-	-	30,000	70,350,015.00	2,01%
	Нийт	1,492,537	3,500,000,011.26	100%	970,103,256.85	970,103,256.85	1,492,537	3,500,000,011.26	100%